



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 471

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 264 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-д хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/-д үүрэг болгосугай.

1/ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн чанар, тээвэр, баталгаат агуулах, лабораторийн стандартыг хангуулж, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, болзошгүй эрсдэлээс сэргийлж ажиллах;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдэд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний нөхцөлийг тогтоох, төлбөр тооцоо, арилжааны хяналтын програм хангамжийг сайжруулах арга хэмжээг Хорооноос баримталж буй бодлого, баталсан дүрэм, журамтай нийцүүлж ажиллах;

3/ Биржийн төлбөр тооцооны төвийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооноос баталсан дүрэм, журмын хүрээнд нийцүүлж, төлбөрийн үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах санг байгуулж ажиллах;

4/ Арилжаа, төлбөр тооцоо, гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Хороогоор батламжлуулах;

5/ Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт зохих өөрчлөлтийг бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

3. Энэ тогтоолын 2-д заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд улсын байцаагчийн албан шаардлагаар арилжааг зогсоох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авахыг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/-д анхааруулсугай.

4. Энэ тогтоолын 1-д заасан тусгай зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам /П.Сэргэлэн/-д дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвлөсүгэй:

F:\ajil 2017\Blank\Tushaal.doc

0111233

1/ Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, компанийн засаглал, тайлагналын ил тод байдлыг хангуулж, боловсон хүчний чадавхыг сайжруулах, арилжаалагдах бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр Хороотой хамтран ажиллах;

2/ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг 2017 онд багтаан байгуулах ажлыг зохион байгуулах;

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасгай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН